

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ӨМИРГҮЛ ТАНАА

2023 о.д. 17 № 63
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн эзэмшилд байгаа газрыг 124.5 сая төгрөгөөр үнэлж шинээр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>115,196,226.99</u>	<u>177,372,419.34</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	59,757,830.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	59,757,830.00
3121	Төгрөг	-	59,757,830.00
31211	Төрийн сангийн харилцах	-	59,757,830.00
33	АВЛАГА	-	157,500.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	157,500.05
35	БАРАА МАТЕРИАЛ	115,196,226.99	117,457,089.29
351	Түүхий эд материал	145,455.00	145,455.00
35130	Эм боох материал	145,455.00	145,455.00
354	Хангамжийн материал	115,050,771.99	117,311,634.29
35410	Бичиг хэргийн материал	1,252,350.00	1,252,100.00
35420	Аж ахуйн материал	79,753,257.39	78,511,177.39
35440	Түлш, шатах тослох материал	7,528,445.50	738,000.00
35460	Хүнсний материал	25,869,719.10	27,855,752.90
35470	Бусад хангамжийн материал	647,000.00	8,954,604.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,887,888,294.94</u>	<u>3,959,086,019.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,887,888,294.94	3,959,086,019.18
392	Биет хөрөнгө	3,882,788,311.50	3,829,491,687.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,962,329,805.26	3,918,056,129.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(197,069,041.74)	(239,807,201.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,464,098.00	86,140,248.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(85,454,083.92)	(44,005,647.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,860,542.66	70,058,418.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,680,428.76)	(31,583,718.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,001,000.00	12,001,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(583,383.36)
39217	Ном	54,336,420.00	59,215,842.00
393	Биет бус хөрөнгө	5,099,983.44	129,594,331.94
39301	Програм хангамж	849,950.00	849,950.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(749,966.56)	(841,618.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	129,586,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,003,084,521.93</u>	<u>4,136,458,438.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,214,500.00</u>	<u>35,694,940.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,214,500.00	35,694,940.00
413	Өглөг	11,214,500.00	35,694,940.00
4136	Бусад өглөг	11,214,500.00	35,694,940.00
41361	Байгууллагад төлөх өглөг	11,214,500.00	35,694,940.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,991,870,021.93	4,100,763,498.52
51	Засгийн газрын хувь оролцоо	3,991,870,021.93	4,100,763,498.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	152,806,215.00	277,392,215.00
51101	Өмч: - төрийн	152,806,215.00	277,392,215.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,503,672,377.05	1,491,447,430.88
51210	Өмнөх үеийн үр дүн	1,503,672,377.05	1,507,139,954.29
51220	Тайлант үеийн үр дүн		(15,692,523.41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,335,391,429.88	2,331,923,852.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,003,084,521.93	4,136,458,438.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,368,016,262.00	1,373,751,616.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,723,640.00	8,307,604.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,723,640.00	8,307,604.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,723,640.00	8,307,604.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,723,640.00	8,307,604.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,366,292,622.00	1,365,444,012.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,313,519,740.00	1,229,780,112.83
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,187,394,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,373,904,240.00	42,385,412.83
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	939,615,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,662,933.00	1,137,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,662,933.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,137,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,784,000.00	134,526,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,784,000.00	134,526,900.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,325,949.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,325,949.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,135,979,362.58	1,389,444,140.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,979,362.58	1,389,444,140.24

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,490,878.58	1,344,224,989.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,506,163.00	899,997,962.95
210101	Үндсэн цалин	656,305,563.00	719,553,162.95
210102	Нэмэгдэл	-	155,189,700.00
210104	Урамшуулал	41,897,600.00	25,255,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,303,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,232,100.00	101,897,800.00
210201	Тэтгэврийн даатгал	68,422,500.00	73,346,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,202,300.00	2,664,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,762,000.00	6,903,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,440,500.00	1,725,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,404,800.00	17,258,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,385,550.00	75,194,650.00
210301	Гэрэл, цахилгаан	3,074,000.00	5,474,000.00
210302	Түлш, халаалт	39,311,550.00	69,720,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,004,557.00	18,360,065.50
210401	Бичиг хэрэг	1,823,883.00	6,180,450.00
210402	Тээвэр, шатахуун	1,475,724.00	3,499,735.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,227,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,477,150.00	8,679,880.00
2105	Нормативт зардал	88,548,842.90	117,536,522.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,694,285.00	898,860.00
210502	Хоол, хүнс	83,795,557.90	115,375,662.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,059,000.00	1,262,000.00
2107	Томилолт, зочны зардал	285,600.00	-
210702	Дотоод албан томилолт	285,600.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,677,946.00	5,865,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,177,946.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,865,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,850,119.68	125,372,988.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	11,959,100.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,663,350.00	1,093,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,186,769.68	112,320,688.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,488,484.00	45,219,151.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,428,409.00	45,019,134.20
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,325,949.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,102,460.00	45,019,134.20
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,060,075.00	200,017.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,060,075.00	200,017.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,232,036,899.42</u>	<u>(15,692,523.41)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,232,036,899.42</u>	<u>(15,692,523.41)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>992,388,382.00</u>	<u>1,323,058,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>992,388,382.00</u>	<u>1,323,058,600.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	939,615,500.00	1,187,394,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,187,394,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	939,615,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,662,933.00	1,137,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,662,933.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,137,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,784,000.00	134,526,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,784,000.00	134,526,900.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,325,949.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,325,949.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>982,261,682.00</u>	<u>1,248,364,210.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>982,261,682.00</u>	<u>1,248,364,210.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>946,841,158.00</u>	<u>1,199,910,653.00</u>

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,580,925.00	894,227,163.00
210101	Үндсэн цалин	644,381,025.00	713,609,995.00
210102	Нэмэгдэл		156,959,589.00
210104	Урамшуулал	41,897,600.00	23,657,579.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,302,300.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,232,100.00	107,826,100.00
210201	Тэтгэврийн даатгал	68,422,500.00	73,310,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,202,300.00	8,628,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,762,000.00	6,903,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,440,500.00	1,725,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,404,800.00	17,258,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,011,200.00	46,874,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,051,200.00	5,474,000.00
210302	Түлш, халаалт	34,960,000.00	41,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,485,633.00	-
210401	Бичиг хэрэг	501,933.00	
210402	Тээвэр, шатахуун	1,181,300.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,227,800.00	
210404	Ном, хэвлэл	54,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,520,600.00	
2105	Нормативт зардал	63,462,100.00	112,753,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	899,700.00	
210502	Хоол, хүнс	56,835,400.00	112,753,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,727,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	750,000.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	353,200.00	-
210702	Дотоод албан томилолт	353,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,055,300.00	6,149,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,555,300.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,149,000.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,910,700.00	31,480,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	23,995,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,910,700.00	7,484,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,420,524.00	48,453,557.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,360,449.00	48,253,540.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,325,949.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,034,500.00	48,253,540.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,060,075.00	200,017.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,060,075.00	200,017.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,126,700.00	74,694,390.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,126,700.00	14,936,560.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,126,700.00	14,936,560.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,126,700.00	14,936,560.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,126,700.00	14,936,560.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,126,700.00)	(14,936,560.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	59,757,830.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		59,757,830.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,806,215.00	2,335,391,429.88	1,503,672,377.05	0.00	3,991,870,021.93
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	152,806,215.00	2,335,391,429.88	1,503,672,377.05	0.00	3,991,870,021.93

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,467,577.24		3,467,577.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,806,215.00	2,335,391,429.88	1,507,139,954.29	0.00	3,995,337,599.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-3,467,577.24			-3,467,577.24
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	124,586,000.00				124,586,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-15,692,523.41		-15,692,523.41
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,392,215.00	2,331,923,852.64	1,491,447,430.88	0.00	4,100,763,498.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,321,921,600.00	1,261,963,753.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,321,921,600.00	1,261,963,753.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,079,300.00	1,213,710,213.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,005,100.00	894,227,163.00
210101	Үндсэн цалин	720,560,300.00	713,609,995.00
210102	Нэмэгдэл	155,189,700.00	156,959,589.00
210104	Урамшуулал	25,255,100.00	23,657,579.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,862,100.00	107,826,100.00
210201	Тэтгэврийн даатгал	73,346,100.00	73,310,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,628,900.00	8,628,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,903,300.00	6,903,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,725,800.00	1,725,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,258,000.00	17,258,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,874,000.00	46,874,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,474,000.00	5,474,000.00
210302	Түлш, халаалт	41,400,000.00	41,400,000.00
2105	Нормативт зардал	162,618,700.00	112,753,690.00
210502	Хоол, хүнс	162,618,700.00	112,753,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,572,500.00	6,149,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,572,500.00	6,149,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,346,900.00	45,280,260.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,488,200.00	35,421,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,858,700.00	9,858,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,842,300.00	48,253,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,842,300.00	48,253,540.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,842,300.00	48,253,540.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,321,921,600.00	1,321,721,583.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,187,394,700.00	1,127,636,870.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,187,394,700.00	1,187,394,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,526,900.00	134,326,883.00
132001	Орон нутгийн төсвөөс	134,526,900.00	134,326,883.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		59,757,830.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	81	81
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40
620003	Үйлчлэх ажилтан	31	31
620004	Гэрээт ажилтан	9	9
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	430	430
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	430	430
630001	Төрийн өмчит ЕБС	430	430
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	81	81
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	40	40
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	40	40

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,137,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,137,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,137,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,137,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,137,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,137,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,137,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,137,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн зорилго нь “хичээлийн бэлтгэлийг сайтар хангах, сурагч бүрийг сурлагын түвшинг ахиулах, багш нарын ажлын байранд хөгжих боломжийг бүрдүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч нарын оролцоог нэмэгдүүлэхэд оршино”.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Багш бүр баг, бүлгээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн хөгжлийн баг үүсгэж ажиллах.
- Бусад аймгийн нэг тэргүүн туршлагыг сургалт үйл ажиллагаанд нэвтрүүлэх.
- Монгол хэлний ур чадварыг сайжруулахад анхаарах
- Сайн хичээл, багш солилцоо хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, чанартай зохион байгуулах.
- Заах аргын нэгдэл тус бүр нэг сайн хичээлийг mecle.mn сайтад байршуулах.
- Сургуулийн үйл ажиллагаанд асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулах сургах, хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- “Дотуур байр-миний гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн захирлын 2019 оны тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		59,757,8	59,757,8
Авлага		157,5	157,5
Бараа материал	115,196,2	117,457,1	2,260,9
Үндсэн хөрөнгө	3,887,888,3	3,959,086,0	71,197,7
Нийт хөрөнгө	<u>4,003,084,5</u>	<u>4,136,458,4</u>	133,373,9
Өр төлбөр	11,214,5	35,694,9	24,480,4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,991,870,0	4,100,763,5	108,893,5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>4,003,084,5</u>	<u>4,136,458,4</u>	133,373,9

Жилийн эцэст 59.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Авлагын данс 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлттэй холбоотой байна.

Бараа материалын данс 2.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнсний материал болон бусад хангамжийн материал авсантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 24.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 160 хүүхдийн багтаамжтай хоёр давхар сургуулийн шинэ байр ашиглалтад орсон боловч халаалтын зардлын төсөв дутуу баталсантай холбоотой үүссэн түлш халаалтын өр 22.9 сая төгрөг, "Ай-Елнур ХХК"-аас авсан худалдаж авсан сурагчийн ширээний үнэ 1.6 сая төгрөгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 71.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 16.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, БШУЯ-наас нийлүүлсэн 42.4 сая төгрөгийн хөрөнгө, улсын тооллогын бүртгэлээр орлого авхуулсан тус сургуулийн кадастрд байсан газрыг 124.5 сая төгрөгөөр үнэлж бүртгэснээр нэмэгдэж, тайлант онд 143.4 сая төгрөгийн хөрөнгийг акталсан болон тухайн оны элэгдлийн зардалтай холбоотой буурсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 108.8 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1586.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 158.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 33.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31.8 сая төгрөгөөр, нормативт зардал 91.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4.4 сая төгрөгөөр бууруулж бараа үйлчилгээний бусад зардлыг 34.7 сая төгрөгөөр нэмэгдэж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1321.9 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1321.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 0.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 59.7 сая төгрөгийг жилийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1261.9 сая төгрөг буюу 95.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/сая төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	2.6	2.0	0.6	76.9
2	Сургалт семинар	1.3	1.3	0	100%
3	Эрүүл мэндийг дэмжих	3.0	3.0	0	100%
4	үдийн цай хөтөлбөр	49.8	48.2	1.6	96.7%
5	Дотуур байрны үйлчилгээ	230.8	181.0	49.9	78.4%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	11.9	11.7	0.2	98.3%
7	Боловсролын байгууллагын багш	5.9	5.9	0	100%
8	Боловсролын стандарт	649.1	647.2	1.9	99.7%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	232.7	225.9	6.8	97.0%
10	Нийтлэг үйлчилгээ	134.5	134.3	0.2	99.8%
	Дүн	1321.8	1261.9	59.9	95.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд түрээсээр олгосон номоос 1.3 сая төгрөгийн орлого оруулж, түрээслүүлэгч нарт төлсөн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1118.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 11.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль нь оны эцэст орон нутгийн төсвөөс хэмнэсэн 0.2 сая төгрөгийг төвлөрүүлэн, улсын төсвийн санхүүжилтийн хэмнэсэн 59.7 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан, алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1321.9 сая төгрөгийн 12 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 1321.9 сая төгрөгийн 12 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хоолны зардалтай холбоотой 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, үндсэн хөрөнгө, бараа материалын данс бүртгэлтэй холбоотой 433.9 сая төгрөг, Шилэн дансны хууль болон Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчилд албан шаардлага өгөгдсөнөөс хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1361.0	1	1361.0	100%
Албан шаардлага	3	433898.7	3	433898.7	100%
Зөвлөмж					
Нийт дүн	4	435289.7	4	435289.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 12.8 сая төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан 11.7 сая төгрөгийн гүйлгээг биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусгалгүй үйл ажиллагааны зардалд оруулан тайлагнасан, Нэмэлт санхүүжилтийн 1.1 сая төгрөгийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд оруулан тайлагнасныг залруулж, Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгав.

Аудитаар нийт 10.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8.4 сая төгрөгийн зөрчилд нэг албан шаардлага хүргүүлсэн болно.

5.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирал нь шинэчлэн баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг зөрчиж 1,2 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Сургуулийн дотуур байрны 29563 хүүхдийн хоолонд нийтдээ 111.2 сая төгрөгийн хүнсний материал зарцуулж хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормтой харьцуулахад жилийн дүнгээр 8.4 сая төгрөгийг батлагдсан нормоос хэтрүүлсэн зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан	1	11687.0			1	11687.0	1	11687.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1	1137.0			1	1137.0	1	1137.0				
Дүн	2	12824.0			2	12824.0	2	12824.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомж зөрчиж илүү олгосон ур чадвар	1	1273.5	1	1273.5								
Хоолны зардлын нормын хэтрэлт	1	8474.2			1	8474.2						
Дүн	2	9747.7										

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								